



АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ШУУРХАЙ ЗӨВЛӨГӨӨНӨӨС ӨГӨГДСӨН ҮҮРЭГ ДААЛГАВРЫН ХЭРЭГЖИЛТ



2024 оны 03 дугаар сарын 04-ний өдөр

ОРХОН АЙМГИЙН ЗАСАГ
ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР



1. Цаг агаар эрс хүйтэрч байгаатай холбоотойгоор эрсдэл, ослоос урьдчилан сэргийлэх, малчдын эрүүл мэндийн асуудалд онцгой анхаарах, түргэн тусламж үзүүлэх шаардлагатай цэгүүдийг тодорхой болгох, техник хэрэгслийн бэлэн байдлыг хангах.

Хугацаа: Тухай бүрд





Биелэлт: ЭМГ, БОЭТ

Эрүүл мэндийн газрын даргын 2024 оны А/11 дүгээр тушаалаар ЭМБ-уудыг өндөржүүлсэн бэлэн байдалд шилжүүлэн, Жаргалант сум, Малчин багт 8 чиглэлд малчдад эрүүл мэндийн үзлэг оношилгоо хийх нарийн мэргэжлийн эмч, резидент эмч нарын баг, хуваарь, бэлэн байдлыг хангах үүрэг чиглэлийг баталсан.

Хуваарийн дагуу 2024 оны 03 дугаар сарын 02-ны өдөр ЭМГ-ын даргаар ахлуулсан баг Жаргалантын Хонгор овоо, Илжгэн, Дугуйн даваан чиглэлд 200км-ын радиуст 25 малчин өрх айлд, БОЭТ-ийн даргаар ахлуулсан баг Уртын гол, Бугын бэлчир, Арцат, Моностой чиглэлд 150 км-ын радиуст 20 малчин өрх айлд очиж, дотор, зүрх судас, эх барих, хүүхэд, дүрс оношилгоо зэрэг нарийн мэргэжлийн эмч үзлэг оношилгоо хийн малчдад шаардлагатай эмийн багц 45 ширхгийг олгосон.

Хэрэгжилт: Хэрэгжиж байна.



2. Улсын онцгой комиссоос “What3words” буюу “3 үгт хаяг” байршил тогтоох гар утасны аппликейшнийг малчдын утсанд суулгаж өгөх мэдээ мэдээллийг олон нийтэд хүргэх ажлыг зохион байгуулах.

Хугацаа: Тухай бүрд





Биелэлт: ОБГ

Баян-Өндөр сум, Жаргалант сумдын багийн хэсгийн ахлагчаар дамжуулан малчин болон мал бүхий 797 өрхийн 1049 иргэний гар утсанд What3words аппликейшныг суулган ашиглах зааврыг өгсөн. Гал түймэр унтраах, аврах 58 дугаар ангийн Гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагчийн 04/01 албан мэдэгдлээр Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын 32 бүтцийн нэгж, цех, хэсгүүдэд албан мэдэгдэл хүргүүлж 4653 ажилтан, ЭДЦС ТӨХК-ийн 460 ажилтан, Онцгой байдлын газрын орлогч, Урьдчилан сэргийлэх тасгийн даргын баталсан хуваарийн дагуу нийт бие бүрэлдэхүүн аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй төрийн болон хувийн хэвшлийн аж ахуй нэгж байгууллагууд, ерөнхий боловсролын сургууль, сургуулийн өмнөх боловсролын байгууллагын багш ажилчдад What3words аппликейшныг танилцуулж, 10833 ажилтан алба хаагч бүрд хэрэглэж хэвших, гэр бүлийн гишүүддээ ашиглах талаар сурталчилгаа хийсэн. Нийт 37084 иргэн буюу аймгийн иргэдийн 30.9 хувьд What3words аппликейшныг суулган ашиглах зааврыг өгсөн.

Хэрэгжилт: Хэрэгжиж байна.



3. Шар усны үер болон бусад байгалийн давагдашгүй хүчин зүйлээс урьдчилан сэргийлж ажиллах. Бэлэн байдлыг хангахад анхаарах. Аж ахуй нэгж, байгууллагуудыг татан оролцуулах (үерийн далан, суваг шуудууг цэвэрлэх, үзлэг шалгалт хийх)

Хугацаа: Тухай бүрд

МАЙРАМДАА - ДРЭЖБА



Биелэлт: ХЗА

2024 оны 02 дугаар сарын 26-ны өдөр хотын үерийн даланд ХЗА, ОБГ хамтран үзлэг хийсэн. Үзлэгээр гэр хорооллын үерийн сувагт ахуйн хог хаягдал ихтэй цасны хунгар бага тогтсон байна. Баян-Өндөр хайрханы ар тал, Даваат, Яргуйт, Баян-Овоот багийн уулархаг хэсэгт цасны зузаан 8-15см, хунгарласан хэсэгт 45-55см-ын цасны зузаантай байна.

2024 оны 03 дугаар сард хүйтний эрч эрчимтэй суларч гадна агаарын температур нэмэх градуст орсон тохиолдолд шар усны үер болох эрсдэлтэй байна. Үерийн сувгийн цэвэрлэгээг 2024 оны 03 дугаар сарын 20-оос хойш цас хайлж эхлэх үед хийхээр төлөвлөж байна.

Хэрэгжилт: Хэрэгжих шатандаа.



4. Барилгын суурь ухаж буй аж ахуй нэгжүүдийн шороог Говил багийн Булагтын усны халиа үүсдэг хэсэгт буулгаж далан барих асуудлыг судалж танилцуулах.

Хугацаа: Тухай бүрд





Биелэлт: ХЗА

Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ, Дорнын чимэг ХХК, Хот тохижуулах газартай хамтран 9 удаагийн татан авалтаар Говил багийн Булагтын хэсэгт 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрөөс 03 дугаар сарын 01-ний өдрийг хүртэл 336 м³ шороог шар усны үерээс урьдчилан сэргийлэх зорилгоор буулгаж, далан үүсгэн ажиллаж байна.

Баян-Өндөр сумын ЗДТГ-т Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-аас "Уурхайчин 2" орон сууцны хорооллын барилгын суурийн талбайгаас гарсан 43024 м³ шороог Говил багийн Булагтын хэсэг рүү зөөвөрлөж буулгуулах саналыг аймгийн ЗДТГ-ын ХБТХОХ-т хүргүүлсэн.

Хэрэгжилт: Хэрэгжиж байна.



5. Ерөнхий боловсролын сургуулиудын ширээ сандлыг шинээр солих шаардлагатай тооцоо судалгааг гаргах. Мөн цэцэрлэгүүдэд шаардлагатай тоглоомын судалгааг гаргаж танилцуулах.

Хугацаа: Ойрын хугацаанд





Биелэлт: НБХ

БШУГ-аас ЕБС-ийн ширээ сандлыг солих тооцоо, судалгааг гаргасан. Шинээр ашиглалтад орох сургууль болон одоо үйл ажиллагаа явуулж буй сургуулиудад нийт 2500 ширээ, сандал солих шаардлагатай байна.

Мөн цэцэрлэгийн ахлах, бэлтгэл бүлгийн хүүхдэд тохирсон модон болон хуванцар 10 төрлийн 432.6 сая төгрөгийн, бага дунд бүлгийн насанд тохирсон 10 төрлийн 691.9 сая төгрөгийн, нийт 20 төрлийн 1124.5 сая төгрөгийн тоглоом шаардлагатай гэсэн тооцоолол гаргасан байна.

Хэрэгжилт: Биелсэн.

НАЙРАМДАА - ДҮЭЖДА



6. Орон нутгийн төсвийн тодотголын асуудалд анхаарч бэлтгэл хангах.

Хугацаа: Ойрын хугацаанд





Биелэлт: ХБТХОХ

Орон нутгийн төсвийн тодотгол хийх ажлын хэсэг байгуулагдсантай холбогдуулан 6 байгууллагаас 50 төсөл арга хэмжээний саналыг хүлээн авч нэгтгээд байна.

Хэрэгжилт: Хэрэгжиж байна.





АНХААРАЛ ХАНДУУЛСАНД БАЯРЛАЛАА

2024 он

НАЙРАМДАЛ - ДРЧУЖДА

